



**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2024 оны 09 сарын 27 өдөр

Дугаар А/86

Улаанбаатар хот

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн
журам, зөвлөлийг шинэчлэн байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дах заалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2, 27.3, Хөдөлмөрийн сайдын 2015 оны 6 дугаар сарын 22-ны А/114 дүгээр тушаал, Зам тээврийн хөгжлийн төвийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.12. дах заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь

1. Үйлдвэрийн газрын захирлын 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн А/38 дугаар Ажил албан тушаалын жагсаалт шинэчлэн батлах тухай тушаалаар бүтэц орон тоо өөрчлөгдсөнтэй холбогдуулан хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүрэгтэй Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, Зам, тээврийн хөгжлийн газрын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн журмыг хоёрдугаар хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн ажиллах журмыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж мөрдөж ажиллахыг үйлдвэрийн газрын нийт ажилтан, алба хаагчдад, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг зөвлөлийн дарга, (Д.Ганболд)-д үүрэг болгосугай

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ерөнхий инженер (Д.Базарсад)-д даалгасугай.

4. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан захирлын 2022 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн А/74 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.


ЗАХИРАЛ



Х.ПҮРЭВЖАРГАЛ

16241187

Зам, тээврийн хөгжлийн төвийн захирлын
2024 оны 09 дүгээр сарын 17 өдрийн 07.80
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ ТӨҮГ-ЫН ХӨДӨЛМӨРИЙН НӨХЦӨЛИЙГ САЙЖРУУЛАХ,
ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ, ХЯНАЛТ ТАВИХ ҮҮРЭГ БҮХИЙ ХӨДӨЛМӨРИЙН
АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ЗӨВЛӨЛИЙН НЭРС

Зөвлөлийн дарга:

Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга:

ХАБЭА хариуцсан ахлах мэргэжилтэн

Гишүүд:

Бодлогын хэрэгжилт, зураг төслийн магадлал, стандарт, норм, нормативын хэлтсийн дарга

Эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийн хэлтсийн дарга

Барилга, угсралтын хяналтын хэлтсийн дарга

Авто замын ашиглалтын хэлтсийн дарга

Төлбөр авах үйл ажиллагааны хэлтсийн дарга

Авто замын итгэмжлэгдсэн төв лабораторийн эрхлэгч

Ерөнхий нягтлан бодогч

Төлбөр авах үйл ажиллагааны хэлтсийн ерөнхий нягтлан бодогч


Хууль, гэрээний мэргэжилтэн

Хүний нөөц өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтэн

Үйлдвэрчний хорооны дарга

...оОо...

Зам, тээврийн хөгжлийн төвийн захирлын
2024 оны 09 дүгээр сарын 08 өдрийн 1786
дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Энэхүү журмын зорилго нь “Хөдөлмөрийн тухай хууль”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль” Зам, тээврийн хөгжлийн төвийн дотоод дүрэм журмын дагуу “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй” /цаашид ХАБЭА/-н шаардлага, стандартыг ханган, ажилтны эрүүл аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад орших бөгөөд Зам, тээврийн хөгжлийн хөгжлийн төв /цаашид Үйлдвэрийн газар/ нь энэхүү журмыг удирдлага болгон ажиллана.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

2.1 Үйлдвэрийн газрын үндсэн болон гэрээт ажилтнууд, үйлдвэрлэлийн дадлага хийж буй их, дээд сургуулийн оюутан, коллеж мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн суралцагч нар мөрдөн ажиллана.

ГУРАВ. НЭР ТОМЪЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

4.1. Энэхүү журманд дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.

“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй” гэж хөдөлмөрлөх явцад хүний ажиллах чадвар, эрүүл мэндийг хэвээр хадгалах, эрүүл ахуйн нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн нийгэм, эдийн засаг, зохион байгуулалт, техник технологи, ариун цэвэр, эрүүл ахуй арга хэмжээ авах, эмчлэх, сувилах, нөхөн сэргээх, эрсдэлээс хамгаалах үйл ажиллагаа.

4.2. “Хөдөлмөрийн аюулгүй байдал” гэж хөдөлмөрлөх явцад хүний эрүүл мэнд хөдөлмөрлөх чадварт үйлдвэрлэлийн аюултай хортой хүчин зүйлийн нөлөөллийн түвшин нь эрүүл ахуйн зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрэхгүй байхыг.

4.3. “Хөдөлмөрийн эрүүл ахуй” гэж хөдөлмөрлөх явцад хими, физик, биологийн хүчин зүйлээс шалтгаалан хүний биемахбодь, мэдрэл сэтгэхүйд өөрчлөлт орж өвчлөх, хөдөлмөрийн чадвараа түр болон бүр алдахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үйл ажиллагаа.

4.4. “Хөдөлмөрийн нөхцөл” гэж хөдөлмөрийн явцад хүний ажиллах чадвар эрүүл мэндэд дагнасан буюу хамссан байдлаар нөлөөлөх ажлын байрны болон үйлдвэрлэлийн орчныг.

4.5. “Ажлын байран дахь эрсдэл” гэж иргэнийг үйлдвэрлэлийн осол хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчинд хүргэж болзошгүй ажлын байрны нөхцөлийг.

4.6. “Эрсдэлийн үнэлгээ” гэж ажлын байрны эрсдэлд үнэлэлт өгөх үйл явцыг.

4.7. “Ажлын байр” гэж иргэн, ажилтны гүйцэтгэх ажил үүрэгтэйгээр холбоотойгоор хүрэлцэн очих ёстой ажил олгогчийн шууд ба шууд бус хяналтан дор байх бүх байрыг.

4.8. “Хурц хордлого гэж” цацраг болон биологийн идэвхт бодис химийн хорт бодисын нөлөөгөөр хурц, цочмог хэлбэрээр богино хугацаанд хордохыг.

4.9. “Тусгай хувцас” гэж үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаалалт зориулалт бүхий хувцас, гутал, малгай, бээлий, зэрэг хэрэгслийг.

4.10. "Хөдөлмөрийн аюулгүй нөхцөл" гэж ажилтанд нөлөөлөх үйлдвэрлэлийн хортой ба аюултай хүчин зүйлийн нөлөөллийн түвшин нь хөдөлмөрийн аюулгүй байдлын тогтоомон хэм хэмжээнээс хэтрээгүй байхыг.

4.11. "Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн менежмент" гэж хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх бодлого, зорилтыг тодорхойлох, тэдгээрийн хэрэгжилтийг зохион байгуулах, манлайлах, хяналт тавих, үнэлгээ хийх харилцан холбоо бүхий удирдлагын үйл ажиллагааны цогцыг.

4.12. "Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн аюулгүй байдал" гэж зураг төсөл, техникийн баримт бичигт заасан нөхцөлийн дагуу тоног төхөөрөмжийг ажиллуулахад хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны шаардлага хангасан байхыг.

4.13. "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт" гэж хөдөлмөрийн нөхцөл аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар эрх бүхий байгууллагаас тогтоосон хэм хэмжээг.

ДӨРӨВ: ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ЗӨВЛӨЛИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

4.1. Үйлдвэрийн газрын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөл / цаашид "зөвлөл" гэнэ/ -ийг ажил олгогч болон ажилтны төлөөллөөс 13-15 гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр захирлын тушаалаар томилон ажиллуулна. Зөвлөл нь жилд 2-оос доошгүй хуралдана.

4.2. Үйлдвэрийн газар нь ХАБЭА-н асуудал хариуцсан орон тооны мэргэжилтэнтэй байна.

4.3. ХАБЭА-н зөвлөлийг газрын Захиргаа санхүү хэлтсийн дарга, ХАБЭА хариуцсан мэргэжилтэн зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулж төлөвлөгөөг батлуулаж, журмын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллана.

4.4. Хөдөлмөрийн аюултай хортой нөхцөлд ажил үүрэг гүйцэтгэдэг ажилтныг хор саармагжуулах бодис, хүнсний бүтээгдэхүүн, хоолоор үнэгүй хангах ажлыг зохион байгуулах хэрэгжилтийг хянах.

4.5. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин хур хордлогын улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан нь тогтоогдсон ажилтанд хууль тогтоомжийн дагуу нөхөн төлбөр олгох, дүгнэлт санал гаргаж холбогдох шийдвэр гаргуулах.

4.6. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлийг хангах арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөв, төлөвлөгөө, хамтын гэрээнд тусгана.

ТАВ: ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ЗӨВЛӨЛИЙН ГҮЙЦЭТГЭХ ЭРХ, ҮҮРЭГ

5.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлаар тухайн жилд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, төсвийг батлах. Ажлын байр, хөдөлмөрийн нөхцөлд үзлэг шалгалт хийж үр дүнг ажилтнуудад мэдээлэх.

5.2. ХАБЭА-н талаар ажилтны гаргасан санал, хүсэлтийг шийдвэрлэх талаар ажил олгогчид зөвлөмж, өгөх.

5.3. Ажлын байр болон үйлдвэр, үйлчилгээний талбайд нэвтрэн орж, үйлдвэрийн осол, хурц хордлогын нөхцөл байдалтай танилцах.

5.4. Зөвлөл нь үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарснаас хойш 48 цагийн дотор судлан бүртгэх бөгөөд акт үйлдэн зөвлөлийн дарга, гишүүд гарын үсэг зурж, байгууллагын тамга тэмдэг дарсан байна.

- 5.5. Үйлдвэрийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх явцад гарсан иргэдийн гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч ажлын 3 хоногийн дотор магадлан шалгаж шийдвэрлэх
- 5.6. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын шалтгаан, хүчин зүйлийг судлан бүртгэсэн акт, дүгнэлтийг үндэслэн нийт ажилтнуудад осол, хурц хордлого гаргасан шалтгаан, нөхцөл болон цаашид үйлдвэрлэлийн осол хурц хордлого гаргахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах шаардлагатай зөвлөмжийг ажил олгогчид хүргүүлэх.
- 5.7. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль, тогтоомж зөрчсөн албан тушаалтан, ажилтанд хариуцлага тооцох талаар ажил олгогчид санал хүргүүлэх.
- 5.8. Байгууллагын хэмжээнд хөдөлмөрийн эрүүл, аюулгүй нөхцөлийг бий болгох, сайжруулахад идэвхи санаачлагатай ажилласан хүмүүсийг урамшуулах санал оруулах.

ЗУРГАА. АЖИЛ ОЛГОГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 6.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан зөвлөл байгуулах, ажилтныг томилж, чөлөөлөх.
- 6.2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, журмыг зөрчсөн ажилтанд хөдөлмөрийн тухай хууль, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, болон энэхүү журамд заасны дагуу хариуцлага хүлээлгэх.
- 6.3. Ажилтан ажиллагсдыг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан ажлын байранд ажиллах нөхцөл, ажлын хувцас, хамгааллын хэрэгслээр хангах. ажлын байрны хөдөлмөрийн эрүүл ахуй байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй байх нөхцөлийг бүрдүүлэх техник хэрэгслээр хангах.
- 6.4. Хөдөлмөр эрхлэлтийн явцад гарч болзошгүй осол аваар, бэртэл өвчлөлөөс ажилтныг хамгаалах хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн менежмент нэвтрүүлэх.
- 6.5. Ажлын байранд учирч болох аюул ослыг арилгах, хяналт тавих эрсдэлийн үнэлгээ хийх.
- 6.6. Ажлын байрны онцлогт нийцсэн ХАБЭА-н журам зааварчилгааг мөрдүүлэх.
- 6.7. Ажилтнуудын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар шаардлагатай мэдлэгийг эзэмшсэн байх.
- 6.8. Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлогын улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан ажилтан хууль тогтоомжийн дагуу нөхөн төлбөр олгох тусламж дэмжлэг үзүүлэх.
- 6.9. ХАБЭА-н нөхцөлийг хангах арга хэмжээ түүнд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөв төлөвлөгөө, хамтын гэрээнд тусгаж, зориулалтаар нь зарцуулах.
- 6.10. Үйлдвэрийн газрын "Захиргаа санхүүгийн хэлтэс" /цаашид ЗСХ/-тэй хамтран нийт ажилтныг эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт жилд 1 удаа хамруулна. Эрүүл мэндийн үзлэг хийлгэхэд шаардагдах зардлыг ажил олгогч хариуцна.
- 6.11. Хөдөлмөрийн хүнд, хортой нөхцөлд ажил үүрэг гүйцэтгэдэг ажилтны хор саармагжуулдаг хүнсний бүтээгдэхүүн ажлын байранд нь өдөр болгон олгох, томилолтоор хөдөө орон нутагт ажиллаж байгаа ИТА нарт хор саармагжуулдаг хүнсний бүтээгдэхүүнийг нэмэгдэл цалингаар хангана.

ДОЛОО: ХАБЭА ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТНИЙ ЭРХ, ҮҮРЭГ

- 7.1. Үйлдвэрийн газрын ХАБЭА-н асуудал хариуцсан орон тооны ажилтан нь холбогдох хууль, журам зааварчилгааны дагуу хариуцсан ажлыг зохион байгуулна.
- 7.2. Захирлын шийдвэрээр батласан журам, зааварчилгааг ХАБЭА хариуцсан мэргэжилтэн

үйл ажиллагаандаа удирдлага болгон ажиллана.

7.3. ХАБЭА-н хариуцсан мэргэжилтэн Үйлдвэрийн газрын байр, ТАЦ, аж ахуйн хашааны галын аюулгүй байдлыг хангаж, заавар зөвлөгөө өгч ажиллана.

7.4. Удирдах болон нийт ажилтны аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжлийн зохицуулалт, арга зүйгээр хангаж ажиллана.

7.5. Удирдлагын шийдвэрээр шинээр ажилд орсон ажилтанд ХАБЭА хариуцсан мэргэжилтэн хөдөлмөрийн аюулгүй байдлын дүрэм журмыг урьдчилан танилцуулах үүрэгтэй.

7.6. ХАБЭА-н мэдээллийн самбар болон сурталчилгааны зурагт хуудсыг холбогдох газарт байршуулж мэдээллийг шинэчилж байна.

7.7. Мэдээлэл сурталчилгааны ажлыг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажлын байранд зохион байгуулна.

7.8. Зөвлөл болон ХАБЭА хариуцсан мэргэжилтэн нь өдөр тутам ажилтнуудыг шаардлагатай хувцас, хэрэгслийн бүрэн бүтэн байдал, ашиглалтад хяналт тавьж ажиллана.

7.9. Үйлдвэрийн газрын ажилтнуудад ХАБЭА-н сургалтыг зохион байгуулах, ХАБЭА-н удирдлагын тогтолцоог бий болгоно.

НАЙМ. АЖИЛТНУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

8.1. Инженер техникийн ажилтан /цаашид ИТА/-ууд нь хувцас, хамгаалах, хэрэглэл, хортой нөхцөлд ажиллаж байгаа тохиолдолд хор тайлах бүтээгдэхүүн /сүү/ -гээр хангуулна.

8.2. ХАБЭА-тай холбоотой газрын зүгээс зохион байгуулж буй арга хэмжээнд тогтмол оролцох үүрэгтэй.

8.3. ИТА нь машин техник, багаж тоног төхөөрөмжөөс шалтгаалан өөрийн эрүүл мэнд, сэтгэл зүйн тааламжгүй асуудал гарвал холбогдох албан тушаалтанд мэдээлэх, шаардлагатай тохиолдолд ажлаас чөлөө хүсэх, илэрсэн зөрчлийг арилгасны дараа ажил үүргээ үргэлжлүүлэн гүйцэтгэх эрхтэй.

8.4. Өдөр тутам ажил хөдөлмөр хийх үедээ ажлын хувцас, хамгаалах хэрэгслийг тогтмол өмсөж, зүүж хэвших

8.5. ИТА ажлын хувцас, хамгаалах хэрэгслийг заасан нормын дагуу цэвэрхэн, нямбай хэрэглэх, нормын хугацаа дуусаагүй байхад хаяж, үрэгдүүлсэн бол нөхөн төлөх.

8.6. Үйлдвэрийн газрын захирлаар баталсан дүрэм, журам, зааварчилгааг мөрдөн ажиллах.

8.7. ХАБЭА хариуцсан мэргэжилтэн, харьяалах хэлтсийн даргын удирдлагын зүгээс тавьсан аливаа шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.

8.8. Ажилтан болон албан хаагч нь Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон Үйлдвэрийн газарт мөрдөж буй ХАБЭА-н журам, зааварчилгааг дагаж биелүүлэх үүрэгтэй.

8.9. Өөрийн болон бусдын аюулгүй байдалд цаг ямагт анхаарал тавьж ажиллах.

8.10. Автомашин, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлтэй ажиллаж байхдаа ажиллах заавар, аюулгүй ажиллагааны зааварчилгааг чанд мөрдөх, зохих нормын дагуу зөв хэрэглэх, бүрэн бүтэн байдлыг байнга шалгах, өөрийн буруутай үйл ажиллагаанаас болж автомашин, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл эвдэрсэн тохиолдолд нөхөн төлж барагдуулна.

8.11. Хамт ажиллаж буй ажилтан нь ХАБЭА журмыг зөрчсөн аливаа үйлдэл гаргасан тохиолдолд шаардлага тавих, гарсан зөрчлийг мэдээлэх. аюулгүй байдал нь хамтын оролцоотойгоор хэрэгждэг зан үйл болохыг ухамсарлах.

ЕС. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ЗААВАРЧИЛГАА, СУРГАЛТ

- 9.1. ХАБЭА хариуцсан мэргэжилтэн нь Үйлдвэрийн газрын ажилтнуудын ажиллах нөхцөл, ажлын байрны онцлогт тохирсон аюулгүй ажиллагааны зааварчилгааг боловсруулан батлуулан хэрэгжилтийг хангуулна.
- 9.2. Ажлын байрны онцлог нөхцөлөөс хамааран зааварчилгааны хугацаа 1 сараас 6 сар хүртэлх хугацаатай байх ба гарын үсэг зурж баталгаажуулна.
- 9.3. Зааварчилгааг ам болон бичгээр өгч, гарын үсэг зуруулж, баталгаажуулна.
- 9.4. Ажилд шинээр орж байгаа ажилтанд Үйлдвэрийн газрын "ХАБЭА-н журам"-тай холбоотой анхан шатны зааварчилгаа өгч, мэдлэгийг шалгана.
- 9.5. ХАБЭА сургалтыг батлагдсан төлөвлөгөөний дагуу ХАБЭА хариуцсан мэргэжилтэн 1-2 удаа нийт ажилтнуудын дунд зохион байгуулна.
- 9.6. Нарийн мэргэжил арга зүй шаардсан сургалтыг мэргэшсэн сургалтын байгууллагатай хамтран зохион байгуулна.
- 9.7. ХАБЭА асуудалтай холбоотой мэдээлэл, сурталчилгааг ажлын байранд зохион байгуулах ажлыг хэлтсийн дарга, лабораторийн эрхлэгч нартай хамтран зохион байгуулна.
- 9.8. Төлбөр авах цэгийн ахлахуудад ХАБЭА-н сургалт явуулж, зааварчилгааг тогтмол өгч хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллана.

АРВАН: АЖЛЫН БАЙРНЫ ХӨДӨЛМӨРИЙН НӨХЦӨЛ, ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ ТОГТООХ

- 10.1. Ажлын байранд учирч болох аюул ослыг арилгах, хяналт тавих зорилгоор эрсдэлийн түвшин тогтооно.
- 10.2. Ажлын байрны нөхцөл, эрсдэлийн үнэлгээг дотоод нөөцөд тулгуурлан зохион байгуулахаас гадна холбогдох мэргэжлийн байгууллагаар тогтоолгоно.
- 10.3. Эрсдэлийн үнэлгээний дүнг ажилтнуудад танилцуулж, сургалт зохион байгуулах. Эрсдэлийн түвшинд үндэслэн илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажиллах.
- 10.4. Ажлын байрны нөхцөл, эрсдэлийн үнэлгээг хийх явцад гарсан зөрчил дутагдлыг арилгах талаар удирдлагад мэдэгдэж, төлөвлөгөө гарган ажиллах бөгөөд Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ.

АРВАН НЭГ: ХАБЭА-Н АЖЛЫН САНХҮҮЖИЛТ

- 11.1. ХАБЭА болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал нь тухайн жилийн Үйлдвэрийн газрын нийт үйл ажиллагааны зардлын 1.5%-аас багагүй байна.
- 11.2. Батлагдсан зардлын хүрээнд тухайн ажлыг зохион байгуулахад Үйлдвэрийн газрын захиргаа санхүүгийн хэлтэс хяналт тавьж, шаардлагатай машин техник, хэрэгслээр хангана.
- 11.3. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин болон аливаа эрсдлийг арилгахтай холбоотой зардлыг тухайн үед нь Үйлдвэрийн газрын удирдлага холбогдох хууль тогтоомж болон зөвлөлийн саналыг үндэслэн шийдвэрлэнэ.

АРВАН ХОЁР: ЖУРАМ ЗӨРЧИГСДӨД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

- 12.1. Үйлдвэрийн газрын нийт ажилтнууд энэхүү журмын заалтыг зөрчсөн, ажлын байранд олгосон ИТА-ны хувцас, лабораторийн хамгаалах хувцас хэрэгслийг ажил үүрэг гүйцэтгэх үедээ болон зориулалтаар нь өмсөөгүй, ажил үүргээ гүйцэтгэх явцдаа хөдөлмөрийн аюулгүй

ажиллагааны зааварчлгааг мөрдөн ажиллаагүй тохиолдолд, хөдөлмөрийн тухай хууль, дотоод журамд заасан дараах арга хэмжээ авна.

12.2. Сануулах

12.3. Үндсэн цалинг гурван сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах..

АРАВ ГУРАВ: УРАМШУУЛАЛ

13.1. Жил бүрийн эцэст нэг удаа хөдөлмөрийн эрүүл аюулгүй нөхцөлийг хангах, сайжруулахад идэвхи санаачилгатай ажилласан хувь хүн хамт олныг урамшуулах сайшаах.

...oOo...